


БАТЛАВ



**СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АХЛАХ СУВИЛАГЧ НАРЫН МАНЛАЙЛЛЫГ
САЙЖРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

ҮНДЭСЛЭЛ:

Эрүүл Мэндийн Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Дүрэм чиг үүрэг батлах тухай” 105 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны төрөл, зохион байгуулалтаас хамаарч байгууллагын түвшинд сувилахуйн алба, багуудыг байгуулан, ахлах сувилагчийг орон тоогоор ажиллуулж нэгжийн болон төвийн хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага зохион байгуулалт, нөөцийн болон тусламж, үйлчилгээний асуудлыг хариуцан үйл ажиллагаа явуулж ирсэн.

2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Дүрэм чиг үүрэг шинэчлэн батлах тухай” 424 дүгээр тушаал гарч сувилахуйн албаны бүтцийг шинэчлэн өргөжүүлж, албаны болон гишүүдийн ажиллах журмыг батлан, ахлах сувилагч нарын гүйцэтгэх үүрэг, бие даасан байдал, манлайлал, зохион байгуулах чадвар, оролцоо, хяналт хариуцлагыг улам нэмэгдүүлсээр байна.

Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах, сувилагч тусгай мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангахад, сувилахуйн удирдах түвшний мэргэжилтнүүдийн мэдлэг, боловсрол, хандлага, ур чадварыг бие даан хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг зайлшгүй чухалчилж байна.

Тус уралдаан нь тасаг нэгжид ажиллаж буй ахлах сувилагч нарын сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, сувилахуйн асуудлаар баримталж буй тушаал, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдал, журам, аргачлал, удирдамж, хөтөлбөрийн боловсруулалт, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажил үүргийн хуваарилалт, зохицуулалт, сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандарт, асаргаа, сувилгааны өдөр тутмын хэрэгжилтийг хэрхэн хангаж хянаж байгаа байдлыг үнэлэн ур чадварт нь дүгнэлт өгч чадавхжуулахыг зорилго болгож байна.

ЗОРИЛГО:

Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний удирдлагын тогтолцоог бүх шатанд бий болгож, сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, мэргэжил арга зүй, удирдлагын нэгдсэн зөвлөмжөөр хангаж, чанарын хяналтыг сайжруулахад оршино

ЗОРИЛТ :

1. Ахлах сувилагч нарыг удирдан зохион байгуулалт, манлайллын түвшин тодорхойлох
2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад манлайллын оролцоог үнэлэх
3. Ахлах сувилагч нарын өөрийгөө хөгжүүлэх, илэрхийлэх, үүрэг хариуцлагыг үнэлэх
4. Арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмжөөр хангана

ХУГАЦАА:

2026 оны 04 сарын 20-оос 2026 оны 11 сарын 20-ны хүртэл

ХАМРАХ ХҮРЭЭ:

Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч нар

Үнэлгээнд дараах шалгуурыг ашиглана

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур	Онос
Удирдлага, манлайллын үүрэг			
1	Сувилахуйн тусламж, үйлчилгээний эрх зүйн орчны үнэлгээ хийж шаардлагатай асуудлаар удирдамж, заавар, журам, аргачлал батлуулах	Үнэлгээ хийж, шинээр боловсруулсан эрх зүйн баримтын тоо	
2	Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах	Төлөвлөгөө, тайлан	
3	Тасаг, нэгжийн сувилагчдын ажил үүргийн хуваарийг баталж, хяналт тавих, ажлын ачааллыг хөнгөвчлөх үйл ажиллагаа хийгдсэн	Батлагдсан хуваарь, хэрэгжилт, тайлан мэдээ	
4	Байгууллага, сувилахуйн албанаас зохион байгуулж буй арга хэмжээ, гаргаж буй шийдвэрийг хамт олонд мэдээлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг авах	Төлөөлж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүн	
5	Шинээр гарсан тушаал, шийдвэр, эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Тушаал шийдвэрийг танилцуулсан тоо, хэрэгжилтийн дүн	
6	Сувилагч мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах арга хэмжээний төлөвлөлт, ёс зүйн алдаа	Хөндлөнгийн үнэлгээний дүн	

	дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх		
7	Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын үнэлгээ, цалин, урамшуулал, нийгмийн халамжийн асуудлыг төлөвлөх, зохицуулах оролцох, урамшуулах.	Батлагдсан төлөвлөгөө, үнэлгээ, хэрэгжилтийн тайлангийн дүн	
Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр			
8	Чанар сайжруулах ажлын төлөвлөгөөг гарган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Төлөвлөгөө, тайлан, гарсан үр дүн. Баримттай	
9	Үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангасан орчин, нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, тайлан /баримттай/	
10	Байгууллагын хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, үнэлэх зөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих	Үнэлгээ хийсэн тайлан, тоо, үр дүн. Сувилагч нарын гардан үйлдлийн үнэлгээний хувь	
11	Халдвар сэргийлэлт хяналт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гормын хэрэгжилтэд хяналт тавих	Халдварын сэргийлэлт, хяналт, мэргэжлийн алдаанаас сэргийлэх, хянах асуудлаар төлөвлөсөн арга хэмжээ, биелэлт	
12	Тусламж, үйлчилгээний чиглэл, төрөл бүрээр хяналтын хуудас боловсруулж, нэвтрүүлж, хяналт тавьж ажиллах	Тоо, үр дүн, үнэлгээний хувь	
13	Сувилахуйн тусламж, үйлчилгээнд “Сувилгааны түүх”-ийн бичилт, хяналт, чанарыг тогтмол сайжруулж ажиллах	Түүх бичилтийн байдалд хийсэн хөндлөнгийн болон албан үнэлгээний дүн	
14	Сувилагч, үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх, оношийг зөв тавих, оношийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалтыг тасралтгүй зохион байгуулж, бүх сувилагчдыг хамруулж, ур чадварыг нэмэгдүүлэх	Сувилагчийн ур чадварын үнэлгээний дүн	
15	Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээнд нэн	Багаж хэрэгслийн судалгаа, хангалтын хувь	

	шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгаа, түүний хангалтын талаар авсан арга хэмжээ		
16	Тасаг нэгжид гарсан мэргэжлийн алдааг бүртгэх, хэлэлцэх, шийдвэрлүүлэх, хамт олонд сэрэмжлүүлэх зорилгоор мэдээлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах	Бүртгэл, мэдээ, протокол, хэрэгжүүлэн үй ажиллагаа, үр дүн	
17	Сувилахуй болон тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, тойрон үзлэг явуулах	Бүртгэл, мэдээ, протокол, хэрэгжүүлэн үй ажиллагаа, үр дүн	
18	Үйлчлүүлэгч, хамт олны сувилахуйн үйлчилгээний сэтгэл ханамжид тогтмол дүгнэлт хийж ажиллах	Сэтгэл ханамжийн хувь, үр дүн	
19	Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг баталж, дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ	Чанарын шалгуур үзүүлэлтийн тайлан, хувь	
20	Сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчийг таних тодруулах арга ашиглаж, эрсдэл, хүндрэл гарахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.	Хийгдсэн үйл ажиллагаа, үр дүн	
21	Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах, таних аргыг нэвтрүүлж, үйлчлүүлэгчид таатай орчин бүрдүүлнэ.	Хийгдсэн үйл ажиллагаа, үр дүн, бүртгэл, мэдээлэл	
22	Сувилахуйн тусламж, үйлчилгээнд эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн санд мэдээлэх, эрсдэл бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Үнэлгээний хэрэгжилт, авсан арга хэмжээ, бүртгэл, мэдээлэл	
23	Үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангана	Хийгдсэн үйл ажиллагаа	
Сувилахуйн тусламж, үйлчилгээний чиглэлээр:			
24	Сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай асаргаа, сувилгааны иж бүрдэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг хийж, төлөвлөн, хэрэгжүүлнэ.	Судалгаа, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	

25	Тусламж, үйлчилгээнд инновацийг дэмжин, тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, шинэ санаа санаачилагыг нэвтрүүлэх	Сургалтын чиглэл, хамрагдсан хүний тоо, сургалтын үр дүнг тооцсон байх	
26	Сувилахуйн тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тайлагналтыг үнэн зөв, ачаалалгүй хийдэг.	Бүртгэл, тайлан	
27	Сувилахуйн 5 шатлалын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх дадлыг хэвшүүлэх, түүнд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.	Хийсэн үйл ажиллагааны тоо, үнэлгээ	
28	Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандарт, зааврыг мөрдөж, шаардлагатай тохиолдолд эмнэл зүйн хэлэлцүүлэг хийж, үр дүнг тооцон, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ	Зохион байгуулсан эмнэл зүйн хэлэлцүүлгийн тоо, авсан арга хэмжээ	
29	Эмнэл зүйн ур чадварыг хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, ур чадварын шатлал ахиулах арга хэмжээг зохион байгуулна.	Хийсэн үйл ажиллагаа, авсан арга хэмжээ	
30	Сувилахуйн тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тайлагналтыг үнэн зөв, ачаалалгүй хийдэг.	Тайлан мэдээ	
Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр			
31	Тасаг нэгжийн сувилахуйн тусламж, үйлчилгээний өвөрмөц чиглэлээр нотолгоо шаардлагатай сэдэв, судалгааны чиглэл зарлаж, судалгааны ажилд сувилагч нараа өргөнөөр оролцуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, оролцсон сувилагчийн тоо	
32	Судалгааны ажлын үр дүнг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх, шинэ туршлага нэвтрүүлэх ажилд хамт олныг уриалах, манлайлах үйл ажиллагаа	Судалгааны үр дүн, үйл ажиллагааны тайлан	
Сувилагч мэргэжилтнийг хөгжүүлэх төлөвлөгөө			
33	Үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, холбогдох нэгжтэй хамтран ажиллана	Судалгаа, төлөвлөгөө, сургагдсан сувилагчийн тоо	
34	Сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний ажлын байрны таатай орчныг бүрдүүлнэ.	Хийгдсэн үйл ажиллагаа	

34	Шинэ сувилагч, эх баригчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж, сурган дадлагажуулах замаар ажлын байранд тогтвортой ажиллуулах	Зохион байгуулсан сургалт хамрагдсан сувилагчийн тоо	
35	Сувилахуйн сургалтыг төлөвлөн тогтмол явуулж, сургалтын үр дүнд дүн шинжилгээ хийж, үнэлгээний дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авна.	Батлагдсан төлөвлөгөө, авсан арга хэмжээ	
36	Мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, харилцааны соёлыг сайжруулах олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, үр дүн	

Тодруулга: Уралдааны шалгуур үнэлгээнд тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийг улирал бүр нэгдсэн эмнэлгийн ахлах сувилагч нарыг Сувилахуйн алба, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч нарыг Эрүүл Мэндийн Газрын сувилахуйн мэргэжилтэн хяналт тавьж, дүгнэнэ.

Сум, тосгоны үнэлгээг хяналт үнэлгээгээр болон улирлын тайлангаар дүгнэнэ.

Жилийн эцсийн тайланг 2026 оны 11 дүгээр сарын 17-18 ны өдрүүдэд ахлах сувилагч нар биеэрээ оролцож хамгаална.

ҮР ДҮН:

- Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангана
- Ахлах сувилагч нарын мэдлэг, ур чадварын сайжруулна
- Сувилахуйн тусламж, үйлчилгээ, сувилагч нарын үйл ажиллагаанд сэтгэл ханамж дээшилнэ
- Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна

БОЛОВСРУУЛСАН: ЭТХ-ийн Сувилахуй, хөнгөвчлөхийн асуудал

хариуцсан мэргэжилтэн  /С.Сунхар/

ХЯНАСАН: ЭМГ-ын эрүүл мэндийг дэмжих салбар хоорондын хамтын ажиллагаа

байгууллагын дотоод ажил хариуцсан ажилтан

/Ш.Аманбол/